

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

05.18 - 05.22



Коронавирусийн тархалт
2020 оны 1-рулиралд дэлхийн
эдийн засагт хэрхэн нөлөөлж
байгаа тухай шинжээчийн
булангаар хүргэж байна.

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Зах зээлийн үнэлгээгээр бага болон дунд хэмжээтэй компаниудын хувьцаа зах зээлийн үнэлгээ өндөр компаниудаас илүү өсөлт үзүүлсэн байна. Эрчим хүчний болон санхүүгийн салбарын компаниудын хувьцааны ханш цар тахлаас үүдэн харьцангуй бага өсөлттэй байсан байна. Вакцины тухай нааштай мэдээлэл гарсантай холбоотой далайн аялал, аялал жуулчлал болон бусад тансаг хэрэглээний салбаруудын хувьцаа өсөлттэй байлаа. Фейсбүүк компанийн хувьцаа өндөр өсөлттэй байсан нь харилцаа холбооны салбарын ерөнхий өсөлтөд нөлөөлсөн байна. Эрүүл мэндийн салбарын хувьцаа өсөлт багатай байлаа.

Нэмэлтээр мөнгөний болон сангийн бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж магадгүй болсон нь зах зээлд эергээр нөлөөлсөн байна. Ням гарагийн шөнө Холбооны Нөөцийн Сангийн дарга Жером Пауэлл, төв банканд эдийн засгийн удаашралын эсрэг ашиглах олон төрлийн арга хэрэгслүүд байгаа ба "бидний хийж чадах зүйлд хязгаарлалт байхгүй" гэжээ. Пүрэв гарагт Сангийн Яамны нарийн бичгийн дарга Стивен Мнучин, Цагаан Ордны зүгээс одоогийн хэрэгжүүлж буй сангийн бодлогын үр дүнг харахаар хүлээж байгаа боловч нэмэлт бодлого хэрэгжүүлэх "зайлшгүй шаардлага" тулгарч магадгүй гэсэн байна.

Европ: Энэ долоо хоногт эдийн засгууд хэсэгчлэн нээгдэж эхэлсэнтэй холбоотойгоор Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдсан ч АНУ болон БНХАУ-ын зөрчилдөөнтэй холбоотой өсөлт хязгаарлагдмал байлаа. STOXX Europe 600 индекс 3.63%, DAX индекс 6.10%, CAC 40 индекс 4.34%, FTSE MIB индекс 2.79% мөн FTSE 100 индекс 3.54%-аар өссөн байна.

ХБНГУ болон Франц улс хамтран 500 тэрбум еврогийн Европын холбоог сэргээх сангийн хөтөлбөрийг өргөн барьснаар коронавирусийн цар тахлын эсрэг Европын сангийн нэгдсэн хариу арга хэмжээнд томоохон хувь нэмэр оруулжээ. Европын Комисс хөрөнгийн зах зээл дээрээс мөнгө босгож, дотоодын засгийн газруудад зээл хэлбэрээр олгохоос илүүтэйгээр Европын Холбооны зарцуулалтыг дэмжихээр төлөвлөж байна. Гэвч, Австри, Нидерланд, Дани болон Швед зэрэг улсууд тус төлөвлөгөөг эсэргүүцэж, зөвхөн зээл олгохоор бол дэмжинэ гэдгээ мэдэгджээ.

Япон: Энэ долоо хоногт Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байлаа. Nikkei 225 Stock Average индекс 351 пункт буюу 1.75% өсөж 20,388.16 болсон нь өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 13.8% бага байгаа юм. TOPIX индексүүдийн хувьд энэ 7 хоногт ижил хэмжээний өгөөжтэй байсан байна. Тус 2 индекс нь өнгөрсөн жилийн мөн үеийнхтэй харьцуулахад тус тус 14% болон 15%-аар бага үнэлгээтэй байна.

БНХАУ: Энэ долоо хоногт эдийн засгийн томоохон үзүүлэлтүүдийн талаар мэдээ гараагүй ч улс төрийн асуудлууд их гарсан байна. Цагаан Ордоос БНХАУ-д үзүүлэх дарамт шахалтыг нэмэгдүүлж, Бээжингийн зүгээс Хонг Конг дахь үндэсний аюулгүй байдлын хууль тогтоомжийг албадан хэрэгжүүлж эхэлсэн зэрэг нь АНУ болон БНХАУ-ын харилцааг дордуулжээ.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	16,094.91	-0.87% ▼
Dow Jones	АНУ	24,465.16	3.29% ▲
S&P 500	АНУ	2,955.45	3.20% ▲
Nasdaq	АНУ	9,324.59	3.44% ▲
S&P/TSX	Канад	14,913.64	1.88% ▲
FTSE 100	Их Британи	5,993.28	3.34% ▲
S&P/ASX 200	Австрали	5,497.00	1.71% ▲
Nikkei 225	Япон	20,388.16	1.75% ▲
Hang Seng	Хонг Конг	22,930.14	-3.64% ▼

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	99.69
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	93.56
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	93.70
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	101.46
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	100.37
DBM' 2023	USD	7.250%	87.33
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	75.18

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.174	0.00 ▲
Libor 3M	0.369	-0.01 ▼
Libor 6M	0.570	-0.09 ▼
Libor 1YR	0.682	-0.07 ▼
US 2YR Bond	0.168	0.03 ▲
US 3YR Bond	0.207	0.02 ▲
US 5YR Bond	0.333	0.03 ▲
US 10YR Bond	0.659	0.02 ▲

Валютын ханш	2020.05.22	Өөрчлөлт
USD	2,801.20	0.16% ▲
CNY	392.60	-0.36% ▼
EUR	3,054.29	0.97% ▲
RUB	38.91	1.67% ▲
KRW	2.26	-0.44% ▼
JPY	26.07	-0.19% ▼
CAD	1,996.15	0.05% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,734.68	-0.52% ▼
Мөнгө /спот/	USD/t oz.	17.21	3.63% ▲
Зэс	USD/lb.	238.65	2.40% ▲
Нүүрс	USD/MT	56.75	3.99% ▲
WTI газрын тос	USD/bbl.	33.25	12.98% ▲
Brent газрын тос	USD/bbl.	35.13	8.09% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	1.73	4.85% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020. IV	4.7%
Бодлогын хүү	2020. IV	9.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020. IV	9.87%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020. IV	11.32%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020. IV	4.57%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020. IV	17.06%
Зээлийн дундаж хүү /валют/	2020. IV	10.36%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 34 компанийн 601.6 сая төгрөгийн 6,665,989 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Хар хорум пропертийс” /AMT/ компанийн хувьцаа 13.78%-аар буюу хамгийн ихээр өсөж 256.00 төгрөг хүрч хаагдсан бол “Авто импекс” /AOI/ компанийн хувьцаа 13.27%-аар буурч 1,700.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


05-р сарын 122-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,420.4 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 16,094.91 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.87%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2020 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)
Арилжигдсан үнийн дүн	601.6
Зах зээлийн үнэлгээ	2,420,442.6

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	16,094.91	-0.87% ▼
MSE I индекс	7,737.17	-0.30% ▼
MSE II индекс	7,349.74	-0.56% ▼

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Ард санхүүгийн нэгдэл	177,084	238,096,215
Стандарт агрикалчер групп	2,501,539	85,057,426
Ард кредит ББСБ	984,684	72,401,991
Мандал даатгал	1,383,494	60,138,308
Стандарт проперти групп	1,039,493	48,856,171

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Хар хорум пропертийс	256.00	13.78% ▲
Блюская секьюритиз	1,600.00	10.34% ▲
Говь	198.81	3.69% ▲
Эрдэнэ ресурс девелопмент корп	518.00	1.67% ▲
Гермес центр	122.01	0.75% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Авто импекс	1,700.00	-13.27% ▼
Улсын их дэлгүүр	704.98	-12.84% ▼
Монгол шуудан	600.00	-10.04% ▼
Цагаантолгой	1,350.00	-10.00% ▼
Орхондалай	1,470.00	-5.16% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
Ард Секьюритиз	625,519,996
Стандарт Инвестмент	287,331,879
Голомт Капитал	72,971,364
Евразия Капитал Монголиа	55,759,000
Гүүдсек	54,532,029

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	538.00	572,530
Таван толгой	5,420.00	285,445
МИК Холдинг	11,000.00	227,803
Инвескор ББСБ	2,520.00	180,754
Говь	198.81	155,094

Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
---	-----------------	--------------------	-----------------	------------	------------	---------	-----

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТ ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.08.31-НИЙ ДОТОР
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.30-НЫ ДОТОР
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НЫ ӨДӨР
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.30-НЫ ДОТОР
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	715.9	1,000.0	139.7%	35.0	2020.04.07	2020.04.30-НЫ ДОТОР
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.24-НЫ ӨДӨР
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БҮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.04.24-ӨӨС
11	BUK	УЛААНБААТАР БУК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.06.01-ЭЭС
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.08.31-НИЙ ДОТОР
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.05.01-ЭЭС
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.03.15-ААС
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛЫТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.06.30-НЫ ДОТОР
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
23	TAH	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.01-НИЙ ДОТОР
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.05.01-ААС 2020.05.15-НЫ ХООРОНД
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.08.01-НЫ ДОТОР
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.01-ЭЭС
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-НЫ ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙ ДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.05.31-НИЙ ДОТОР

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



ОНЦЛОХ МЭДЭЭ

“Бодь даатгал” компани 5-р сарын 25-наас IPO-ийн захиалга авч эхлэхээ мэдэгдлээ.

Тус компани 20 хувиа олон нийтэд санал болгож, доод тал нь 5.3 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр зорьж байгаа юм. Энэ хүрээнд нийт 47,063,944 ширхэг хувьцааг нэгж бүрийг нь 113 төгрөгөөр санал болгож байгаа юм байна.

Эх сурвалж: Bloomberg TV Mongolia

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

Дараах хувьцаат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулагдана

2020 оны 05-р сарын 22-ны байдлаар дараах хувьцаат компаниуд хувьцаа эзэмшигчдийн хурлаа зохион байгуулахаар болсон байна. Үүнд:

- “Ард санхүүгийн нэгдэл” /MSE: ADB/ XK 2020 оны 06-р сарын 19-ний өглөөний 09:00 цагт (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн, 2 давхар).
- “Е-Моние” /MSE: HCH/ XK 2020 оны 06-р сарын 25-ны өдрийн 13:00 цагт (Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Хот айл ХХК-ийн байр 25 тоот).
- “Хүннү Менежмент” /MSE: HBZ/ XK 2020 оны 06-р сарын 25-ны өдрийн 16:00 цагт (Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Хот айл ХХК-ийн байр 25 тоот).

Covid-19-ийн халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор 05-р сарын 22-ны байдлаар дараах хувьцаат компаниуд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахимаар хийхээр шийдвэрлэсэн байна Үүнд:

- “Хөнгөн Бетон” /MSE: HBT/ XK 2020 оны 05-р сарын 27-ны өдрийн 16:00 цагт (Google Zoom App)

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Ард кредит ББСБ” /MSE: ADB/ XK-аас ногдол ашиг хуваарилсан тайлан ирүүлээ

“Ард кредит ББСБ” /MSE: ADB/ XK-ийн ТУЗ-ийн 2020 оны 02-р сарын 19-ний өдрийн №2020/4 тоот тогтоолоор 2019 оны цэвэр ашгийн 50 хувь буюу нэгж хувьцаандаа 4.23 төгрөгийг ногдол ашиг болгон тараахаар шийдвэрлэсэн боловч 2019 оны санхүүгийн тайланд аудитын залруулга хийгдсэнтэй холбогдуулан ТУЗ-ийн 2020/6 тоот тогтоолоор нэгж хувьцаанд 3.9 төгрөг хуваарилахаар болсон бөгөөд үүний дагуу нийт 1.09 тэрбум төгрөгийн ногдол ашгийг 1,642 хувьцаа эзэмшигчдэд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан бүрэн тараасан байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” /MSE: ERDN/ XK-ийн ирүүлсэн мэдээлэл

2020 оны I улиралд Алтан Нарын ашиглалтын тусгай зөвшөөрлийг хүлээн авсан бөгөөд East Asia компаниар Байгаль Орчин, Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээ хийлгэж цаашид нарийвчилсан үнэлгээг дуусгахад бэлэн болсон. Мөн Баян Хөндийн эцсийн ТЭЗҮ болон анхны инженерчлэл загвар төслийн 3 хэмжээст загварчлалыг гаргасан байна.

Компани 2020 оны 01-р сарын сүүлээс эхлэн COVID-19 вирусийн тархалтаас оролцогч талуудыг хамгаалах арга хэмжээний хүрээнд томилолтын хязгаарлалт хийж, зайнаас ажиллах нөхцөлийг бүрдүүлж, эрүүл мэндийн дэмжлэгийг Монголын болон олон улсын ажилтнууддаа үзүүлснээр бүх оролцогч талууд, үндсэн үйл ажиллагаагаа вирусийн тархалтын эрсдэлээс хамгаалсаар байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Түмэн шувуут” /MSE: TUM/ XK компост бордооны үйлдвэрийг нээлээ

2019 онд үнэт цаасаа олон нийтэд нээлттэй санал болгон гаргасан “Түмэн шувуут” /MSE: TUM/ XK нь үнэт цаасны танилцуулгад тусгасан 4 төрлийн томоохон ажлын нэг болох цэвэр байгалийн 100% компост бордооны үйлдвэрийг нээж, ашиглалтад оруулсан байна.

Энэхүү үйлдвэр нь тахианы сангасыг дэвшилтэт технологиор боловсруулж, Монгол орны байгаль цаг уур, хөрсний онцлогт нийцсэн органик бордоо үйлдвэрлэх бөгөөд ийнхүү ногоон байгууламж, газар тариалан эрхлэгчдэд чухал хэрэгцээтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа нь хөдөө аж ахуйн салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулна гэж салбарын сайд онцолсон байна.

Үйлдвэрийн нээлтийг тохиолдуулан “Түмэн шувуут” /MSE: TUM/ XK-ийн хамт олон Нийслэлийн ногоон байгууламжид хувь нэмрээ оруулж, Нийслэлийн хот тохижилтын газарт 5 тонн 100% Компост бордооны дээжийг хандивласан байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Олон улсын валютын сангийн ажлын хэсэг 2020 оны 05-р сарын 11-13-ны өдрүүдэд Монгол Улсын эрх баригчидтай цахим уулзалт зохион байгуулсан. Тус уулзалтын үеэр Ковид-19 цар тахлын Монгол Улсын эдийн засагт үзүүлж буй нөлөө, өрийн тогтвортой байдал болон бусад асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлээ.

Уулзалтын дараа Шуурхай санхүүжилтийн хэрэгсэлд Монгол Улсыг хамруулах хүсэлтийг хэлэлцэж, төсвийн болон төлбөрийн тэнцлийн яаралтай төлбөрүүдийг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 72.3 сая зээлжих тусгай эрх буюу 99 сая ам.долларын санхүүжилт олгох ОУВС-ийн ажлын хэсгийн түвшний хэлэлцээрт хүрлээ.

Эх сурвалж: BloombergTV.mn



МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Ипотекийн 8%-ийн зээлийн хөтөлбөрийг дахин хэрэгжүүлэхээр Монголбанк өөрийн эзэмшил дэх ипотекийн зээлээр баталгаажсан бондын үндсэн төлбөрийн эргэн төлөлтийн орлогоор, банкнууд Монголбанкнаас олгосон санхүүжилтийн хэмжээнээс багагүй дүнгээр санхүүжилтийг шийдвэрлэхээр боллоо. Уг хөтөлбөрийг УИХ-аас Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, УИХ-ын 2020 оны 32-р тогтоолын дагуу Монголбанк "Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журамд"-д өөрчлөлт оруулан, банкнуудтай гэрээ байгуулснаар хэрэгжүүлнэ.

2020 оны 05-р сараас 2020 оныг дуустал хэрэгжих уг хөтөлбөрийг Монголбанк, арилжааны банкнаас тус бүр 120 тэрбум, нийт 240 тэрбум төгрөгөөр санхүүжүүлнэ.


Эх сурвалж: Монголбанк

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Оны эхнээс 05-р сарын 18-ны өдөр хүртэлх хугацаанд нийт 5.1 сая тонн чулуун нүүрсийг 421.2 сая ам.доллаар борлуулсан талаар Гаалийн ерөнхий газрын урьдчилсан гүйцэтгэлд дурджээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрсний экспорт 2.6 дахин бага хэвээр байна. Одоогоор нүүрсээ Гашуунсухайт, Шивээхүрэн, Ханги, Замын-Үүд боомтоор экспортолж байгаа юм. Оны эхнээс хойш нийт чулуун нүүрсний экспортын 48 хувийг Гашуунсухайт, 30 хувийг Шивээхүрэн боомтоор гаргажээ. Боомтуудын экспорт өссөн ч хэвийн түвшиндээ хүрээгүй хэвээр байна. Тухайлбал: 05-р сарын 18-нд Гашуунсухайт боомтоор 397 автомашин, Шивээхүрэн боомтоор 276 автомашинаар нүүрс гаргажээ. Гашуунсухайтаар өдөрт 500-аас дээш тооны автомашин гарч байж экспорт хэвийн болно гэж "Тавантолгой" ХК үзэж байна.

Эх сурвалж: BloombergTV.mn




ШИНЖЭЭЧИЙН БУЛАН

КОРОНАВИРУС БА ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ


Ковид 19 вирусийн тархалт

05 р сарын 18-ны байдлаар Ковид 19 өөр халдварласан нийт хүний тоо 4.8 сая даваад байна. Үүнээс 1.8 сая хүн эдгэрч, 316 мянга орчим хүн нас барсан байна.



Одоогийн байдлаар вирусийг эдгээх ямар нэгэн эрүүл мэндийн шийдэл байхгүй байгаа бөгөөд тархалтыг бууруулахын тулд дараах үндсэн арга хэмжээг улс орнууд авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- Зай барих /Distancing/
- Аялал жуулчлалыг хязгаарлах
- Шинжилгээ хийж, маршрут мөрдөж (contact tracing) тусгаарлах
- Амны хаалт зүүх, ариун цэвэр хангах




Халдварын тархалтыг бууруулахаар улс орнууд нийгмийн тусгаарлалт, хөл хорио тогтоосон нь үр дүнтэй байгаа ба илүү хатуу хөл хорио тогтоох нь илүү үр дүнтэй байна.

Тархалтын хоёрдогч давлагаа үүсгэхгүйгээр хөл хориог суллах арга хэмжээг хэрхэн авах нь дараагийн асуудал болоод байна.

Эдийн засгийн царцалт


Хөл хорио тогтоосонтой холбоотойгоор эдийн засгийн эргэлт түр зогсолтод хүрээд байна.

Composite PMIs of developed and emerging markets, 2006–2020



БНХАУ-д Ковид 19 ийн халдвар эхэлж гарсан бөгөөд аж үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт, борлуулалт эхний 3 сарын байдлаар бүгд унаад байна.

Chinese industrial production fell further in March



Source: China National Bureau of Statistics, 27 April 2020, 07:00 GMT

BBC


БНХАУ нь Дэлхийн үйлдвэрлэлийн 1/3-г дангаараа гүйцэтгэдэг бөгөөд хамгийн том экспортлогч юм.

Аж үйлдвэрийн тоног төхөөрөмж үйлдвэрлэгч JCB болон автомашин үйлдвэрлэгч Nissan зэрэг олон компанийн нийлүүлэлтийн сүлжээ сааталд орсон байна.

Мөн автомашины дилерүүд эрэлт буурсныг онцолж байгаа ба БНХАУ д 03-р сард автомашины борлуулалт 48 хувиар унаад байна.

Car sales in China have fallen sharply

Week-on-week percentage change




Source: China Passenger Car Association, 27 April 2020, 07:00 GMT

BBC

Ажилгүйдэл

АНУ-д ажилгүйдлийн тэтгэмжийн хүсэлтийн тоо түүхэн дээд түвшинд хүрсэн бөгөөд 05-р сарын эхний 7 хоногийн байдлаар 36 саяыг даваад байна.




SOURCE: Department of Labor. Data is seasonally adjusted.

CNBC


ШИНЖЭЭЧИЙН БУЛАН

КОРОНАВИРУС БА ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Зөвхөн 04-р сард АНУ-д 20.5 сая ажлын байр устаж үгүй болсон нь сүүлийн 10 жилийн ажлын байрны тоон өсөлтийг арилгаад байна.



Ажилгүйдлийн түвшин 14.7 хувьд хүрсэн нь Дэлхийн 2-р дайнаас хойших дээд үзүүлэлт бөгөөд 4-р сарын ажлын байрны уналт нь түүхэн дэх хамгийн өндөр уналт байв.




Ажил эрхлэлт бүх секторуудад огцом унасан ба аялал жуулчлал, зочломтгой үйлчилгээний сектор 7.6 сая, Боловсрол болон эрүүл мэндийн салбар 2.5 сая ажлын байр алдаж хамгийн хүндээр өртсөн байна.

Эдийн засгийн уналт

Эдийн засгийн эргэлт царцсантай холбоотойгоор 2020 оны 1-р улиралд АНУ болон Евро бүсийн орнуудын эдийн засаг уналттай байв.


Евро бүсийн орнуудын 1-р улирлын бодит ДНБ нь 3.8 хувиар унаж блок үүссэнээс хойших түүхэн

уналтыг үзүүлэв. АНУ-ын 1-р улирлын бодит ДНБ өмнөх улиралтай харьцуулахад 1.2 хувиар буюу жилд хөрвүүлэхэд 4.8 хувиар унасан байна.



Энэхүү уналтад хэрэглээний бууралт хамгийн ихээр нөлөөлсөн бөгөөд АНУ-д хөл хорио тогтоох арга хэмжээ 3-р сарын дунд үеэр эрчимжсэнтэй холбоотой.

Улс орнуудын хэрэгжүүлж буй хөл хорио тогтоох хэмжээ их байгаа нь ДНБ-ны уналттай шууд уялдаатай байна.



Улс орнуудын 2-р улирлын ДНБ үүнээс улам муу байх төлөвтэй байгаа ба Bloomberg-ийн судалгаанаас АНУ-ын эдийн засаг 26 орчим хувиар буурах төлөвтэй байна.

2 улирал дараалж ДНБ буурах буюу эдийн засаг уналттай байхыг хямрал гэж тодорхойлдог бөгөөд энэ оны 2-р улиралд АНУ хямралд орох нь тодорхой болоод байна.

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.